## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
## ЗӨВЛӨМЖ

2023.03.03 Дугаар 2023/03 Улаанбаатар хот

"Хан-Уул дүүргийн 2023 оны эхний 2 сарын албан бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тухай"

## НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

### 1.1 Өргөдөл гомдол

Дүүргийн хэмжээнд 2023 оны эхний 2 сард ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, болон гомдлын төрөлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд өссөн дүнгээр нийт 1030 өргөдөл гомдол хүлээн авсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1,4 дахин өсжээ. Шийдвэрлэлтийн хугацаа өмнөх онд 8 хоног 01 цаг байсан бол энэ онд 07 хоног 28 минут болжээ. Нийт өргөдлийн 89,2% нь хугацаандаа буюу нийслэлийн дунджаас 1 хоногоор түрүүлж шийдвэрлэгдэж байна.

(2023 оны эхний 2 сарын байдлаар)

| Хан-Уул дүүрэг | Нийт өргөдөл | | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн | | Судлагдаж байгаа | | Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн | | Шийдвэрлэлтийн дундаж хоног | | Зөрчлийн тоон үзүүлэлт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2022 II/28 | 2023 II/28 | 2022 II/28 | 2023 II/28 | 2022 II/28 | 2023 II/28 | 2022 II/28 | 2023 II/28 | 2022 II/28 | 2023 II/28 | 2022 II/28 | 2023 II/28 |
| ИТХ | 2 | 0 | 2 | | | | | | 02х 01ц 03м | | | |
| ЗДТГ | 60 | 100 | 58 | 82 | 2 | 18 | | | 09х 05ц 02м | 05х 13ц 17м | 1 | 2 |
| Харьяа хэлтэс, албад | 277 | 717 | 251 | 634 | 20 | 80 | 6 | 3 | 06х 18ц 50м | 07х 12ц 18м | 95 | 111 |
| Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд | 5 | 16 | 3 | 16 | 2 | | | | 01х 18ц 53м | 05х 14ц 59м | 1 | 5 |
| Хороод | 29 | 78 | 27 | 69 | 1 | 9 | 1 | | 09х 18ц 34м | 05х 06ц 20м | 8 | 43 |
| Эмнэлэг | 38 | 100 | 37 | 99 | 1 | 1 | | | 08х 20ц 12м | 03х 03ц 25м | 51 | 12 |
| Цэцэрлэг, сургууль | 10 | 19 | 4 | 19 | 6 | | | | 00х 06ц 13м | 03х 09ц 44м | 0 | 11 |
| НИЙТ | 421 | 1030 | 382 | 919 | 32 | 108 | 7 | 3 | 08х 01ц 38м | 07х 00ц 28м | 156 | 184 |

Өргөдөл гомдлын тоо өсөхийн зэрэгцээ хугацаа хэтэрсэн шийдвэрлэлт 57,1 хувиар буурч, зөрчлийн тоо 17,9 хувиар өссөн. Дүүргийн хэмжээнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зөрчилгүй ажиллаж, эрүүл мэндийн салбарын зөрчил 76,5 хувиар буурсан хэдий ч дэргэдэх хэлтэс, албадын зөрчил нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 16,8 хувь, хороодынх 4,4, дүүргийн өмчит газрууд мөн 4 дахин

нэмэгдсэн бөгөөд нийт зөрчлийн 60,3 хувийг дэргэдэх хэлтэс албадын зөрчил эзэлжээ.

**Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн зөрчил**




**Дэргэдэх хэлтсүүдийн 111 зөрчлийн төрөл**




Зөрчилтэй болон хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол нь нийт өргөдлийн 18,1 хувийг эзэлж байгаа тул дүүргийн Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн индекс төдийлөн ахихгүй байна.

Өмнөх оны мөн үед гомдол 372 байсан бол энэ онд 323 болж 13,17 хувиар буурчээ. Нийт гомдлын 74 хувийг дэргэдэх хэлтэс, албад, 14 хувийг Засаг даргын Тамгын газар, 12 хувийг хороод тус тус эзэлж байна. Дэргэдэх хэлтэс албадад ирүүлсэн 239 гомдлын 18 хувийг Цагдаагийн газар, Газар зохион байгуулалтын алба, Эрүүл мэндийн төв тус тус 13 хувь, Эрүүл мэндийн төв, Нийгмийн

даатгалын хэлтэс тус тус 12 хувь, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс 11 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 32 хувь нь бусад хэлтсүүдэд ногдож байна.

**Дэргэдэх хэлтэс, албадын зөрчлийн хувь**




**Дүүрэгт ирүүлсэн - 323 гомдол**






Дэргэдэх хэлтсүүдэд ирүүлсэн гомдлыг төрлөөр нь ангилж үзвэл:

## Цагдаагийн газар-42 гомдол




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| **Иргэний талд** | **23** |
| **Боломжгүй** | **10** |
| **Судалж байгаа** | **8** |
| **Бусад** | **1** |
| **Нийт** | **42** |

## Газар зохион байгуулалтын алба - 31 гомдол




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| **Иргэний талд** | **10** |
| **Боломжгүй** | **14** |
| **Судалж байгаа** | **5** |
| **Бусад** | **2** |
| **Нийт** | **31** |

## Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс - 27 гомдол




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| **Иргэний талд** | **12** |
| **Боломжгүй** | **9** |
| **Судалж байгаа** | **4** |
| **Бусад** | **2** |
| **Нийт** | **27** |

## Боловсролын хэлтэс - 29




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| **Иргэний талд** | **19** |
| **Боломжгүй** | **7** |
| **Судалж байгаа** | **3** |
| **Бусад** | |
| **Нийт** | **29** |

## Эрүүл мэндийн төв -30 гомдол




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| **Иргэний талд** | **28** |
| **Боломжгүй** | **1** |
| **Судалж байгаа** | **1** |
| **Бусад** | |
| **Нийт** | **30** |

## Нэгдсэн эмнэлэг-29 гомдол




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| **Иргэний талд** | **24** |
| **Боломжгүй** | **4** |
| **Судалж байгаа** | **1** |
| **Бусад** | |
| **Нийт** | **29** |

## Улсын бүртгэлийн хэлтэс -15 гомдол




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| Иргэний талд | 13 |
| Боломжгүй | 2 |
| Судалж байгаа | |
| Бусад | |
| Нийт | 15 |

## Нийгмийн даатгалын хэлтэс - 11 гомдол




ШИЙДВЭРЛЭЛТ

| | |
|---|---|
| Иргэний талд | 6 |
| Боломжгүй | 3 |
| Судалж байгаа | 2 |
| Бусад | |
| Нийт | 11 |

Бусад дэргэдэх хэлтсүүдэд 25 гомдол ирүүлсэн бөгөөд төрлөөр нь авч үзвэл:

| | | | |
|---|---|---|---|
| 1 | ТҮТ-9 | Халтиргаа | 9 |
| 2 | Хан-УУл Агро-2 | Хог тээвэрлэлт | 2 |
| 3 | Татварын хэлтэс-4 | 7011-1288 лавлах утас авдаггүй | 3 |
| | | ААН-ийн санхүүгийн тайлан | 1 |
| 4 | ЕБС-2 | 130-р сургуулийн халаалт | 2 |
| 5 | ТТЭМТ-4 | Хүнд сурталтай | 4 |
| 6 | ГБХЗХХ-2 | 108 дугаарын утасны талаар | 1 |
| | | "Ард санхүү нэгдэл" ББСБ насанд хүрээгүй хүүхэд дарамталсан тухай | 1 |
| 7 | ЖДҮДТ-1 | Нэр бүхий албан хаагчийн Ёс зүйн талаар | 1 |
| 8 | ОБХ-1 | Аваарын гарцны эзэмшигчийг цуцлуулах тухай | 1 |
| | | Дүн | 25 |

Хан-Уул дүүргийн хороодод эхний 2 сарын байдлаар 40 гомдол ирүүлснийг төрлөөр нь авч үзвэл:

| Хороо | Нийт гомдол | Иргэний талд | Боломжгүй | Судалж байгаа | Бусад |
|---|---|---|---|---|---|
| 1-р хороо | 2 | 1 | 1 | | |
| 2-р хороо | 4 | 3 | | 1 | |
| 3-р хороо | 3 | 1 | 1 | 1 | |
| 8-р хороо | 1 | 1 | | | |
| 10-р хороо | 3 | 1 | 1 | 1 | |
| 11-р хороо | 2 | 2 | | | |
| 13-р хороо | 1 | | | 1 | |
| 14-р хороо | 1 | | | 1 | |
| 15-р хороо | 2 | 2 | | | |
| 16-р хороо | 2 | 1 | 1 | | |
| 18-р хороо | 1 | 1 | | | |
| 19-р хороо | 10 | 5 | 3 | 1 | 1 |
| 20-р хороо | 2 | 1 | | | 1 |
| 21-р хороо | 1 | 1 | | | |
| 22-р хороо | 1 | 1 | | | |
| 23-р хороо | 3 | 3 | | | |
| 24-р хороо | 1 | 1 | | | |
| Нийт | 40 | 25 | 7 | 6 | 2 |

## ХОРООД - 40




1.2 Албан бичиг

Хан-уул дүүрэгт 2023 оны эхний 2 сарын байдлаар нийт 6372 албан бичиг ирсэн, шийдвэрлэлт 98,92 хувьтай байна.

## ХАН-УУЛ ДҮҮРЭГТ ИРСЭН БИЧИГ-6372



## ҮҮНЭЭС ХУГАЦАА ХЭТЭРЧ ШИЙДСЭН АЛБАН БИЧИГ - 23




## Албан бичиг шийдвэрлэлтийн зөрчил-46




## ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

1. Өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлтэд зөрчил тооцуулсан нэр бүхий албан хаагчид хариуцлага тооцож, эргэн тайлагнаж хэвших,

2. Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд зөрчил тооцуулсан албан тушаалтанд ногдуулах сахилгын арга хэмжээний талаар байгууллагын дотоод журамд тодорхой тусгах;

3. Хэлтэс албадын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнүүд зөрчлийн тоо болон гомдлын тоог бууруулахад идэвх санаачилга гарган гомдлыг барагдуулахдаа бусад хэлбэрээр шийдвэрлэж, хаахгүй байхад анхаарч ажиллах;

4. Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнүүд гомдлыг төрлөөр нь нарийвчлан судалж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулж, удирдлагадаа бодит мэдээллийг тогтмол танилцуулах;

5. Байгууллага, нэгжийн удирдлагууд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд гомдлыг бууруулах чиглэлээр шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ, бусад боломжит шийдлийн талаар санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

6. Бүх хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчил болон гомдлын тоог бууруулахад онцгой анхаарч төлөвлөгөө гарган биелэлтийг сар бүр дүүргийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж хэвших нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖТЭЙ ТАНИЛЦСАН: С.ЭНХБАЯР

Засаг даргын Тамгын газрын дарга

ЗӨВЛӨМЖ ХЯНАСАН: Л.ОТГОНБАЯР

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН: Н.АЛДАРМАА

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн